Ирээдүйн нийгмийн чадамжид суурилсан үндэсний сургалтын хөтөлбөрийн дизайн

Судалгааг удирдсан: Кионхо Ли

Судалгааг хамтран гүйцэтгэсэн: Ёнсун Куок,

Сюнми Ли, Жунсон Чой

I. Судалгааны хэрэгцээ

- **Үндэсний сургалтын хөтөлбөрийн түвшин нь нийгмийн өөрчлөлтийн хурдац, ухаалаг суралцахуйг дэмжих сургууль боловсролын орчны өөрчлөлтийн шаардлагыг хангаж буй эсэхт хариулт өгөх**

  - Үндэсний болон нийгэм, үйлдвэрлэлийн бүтэц, технологийн өөрчлөлт, хөгжил болон суралцагчдад гарч буй өөрчлөлт, ялангуяа суралцагчийн олон талын хэрэгцээ, эрдэм судлалын шинэ салбарууд буй болж, түгэн дэлгэрч байгаа зэрэг нь үндэсний сургалтын хөтөлбөрийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг бүхэлд дахин нягталж үзэхийг шаардаж байна.
  - 21-р зууны нийгмийн эрчимтэй өөрчлөлт нь одоогийн үндэсний хөтөлбөрийн бүтэц, хичээл бүрийн хөтөлбөрийн зорилго, агуулга зэргийг ул үндэстэй шүүн тунгаах, дахин нягталж үзэхийг шаардаж байна.
  - Суралцагсдыг ирээдүйн нийгэмд бэлтгэх сургалтыг үр өгөөжтэй явуулахад зориулагдсан үндэсний сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах суурийг тавих хэрэгцээ байна.

- **Ирээдүйд хэрэгтэй үндсэн чадамжуудыг хөгжүүлэх хэмжигдэхүүнүүдийг нягтлах**

  - Мэдлэгийг хуримтлуулахаас илүүтэй хэрэглэж чаддаг байхыг онцолж буй сургууль боловсролын орчны өөрчлөлт нь одоогийн хичээл буюу судлагдахуунд төвлөрсөн сургалтын хөтөлбөрөөс эрс ялгаатай чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэглэхийг шаардаж байна.
  - 21-р зууны суралцагчдын эзэмших шаардлагатай үндсэн чадамжуудыг тодорхойлох, тэдгээрийг сургуулийн сургалтын хөтөлбөр, сургалт, үнэлгээний явцад үр дүнтэй хөгжүүлэхэд хэрэг болох маш тодорхой хэмжигдэхүүнүүдийг боловсруулах шаардлага байна.
  - Бага, дунд боловсрол, түүний сургалтын хөтөлбөр, сургалт (багшлахуй ба суралцахуй), үнэлгээг сайжруулах цогц хэмжигдэхүүнийг боловсруулах хэрэгцээ нь ирээдүйд хэрэг болох үндсэн чадамжуудыг хөгжүүлэх үйл явцтай салшгүй холбоотой.

II. Судалгааны зорилго

- Ойрын 20 жилд гарч болзошгүй нийгмийн болоод хүрээлэн буй орчны өөрчлөлтийг урьдчилан харж, боловсролын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, сургалтын хөтөлбөрийг сайжруулах чигийг тогтоох
- Урьд өмнө хийгдсэн судалгаа болон Солонгосын нөхцөл байдалд тохирох гадны кейст тодорхойлсон үндсэн чадамжуудыг дахин бүтэцчилж, тохиромжтой, уян хатан байдлыг нягтлан, сургалтын хөтөлбөр дэх үндсэн чадамжуудыг дахин нягталж үзэх үндэс суурийг тавих
- Ирээдүйн нийгэмд амьдрахад шаардагдах үндсэн чадамжуудыг хөгжүүлэх үндэсний сургалтын хөтөлбөр (бүтэц, хүрээ, зохион байгуулалт, хэрэгжилт, баримтжуулах тогтолцоо

г.м) болон тухайн хөтөлбөрт тулгуурласан ахиц дэвшлийг (эзэмшиж буй чадамжуудын) хэмжих хэмжигдэхүүнийг боловсруулах

III. Судалгааны агуулга

- Урьд өмнө хийгдсэн судалгаанд тулгуурлан нийгмийн ирээдүйн өөрчлөлтийн мега-чиг хандлагыг гаргаж, энэхүү мега-чиг хандлагаас үүдэлтэй ирээдүйн боловсролын өөрчлөлтийн чиглэлийг тогтоох
- Мега-чиг хандлагаас урган гарсан үндсэн чадамжууд болон боловсролын ирээдүйн хэрэгцээг нягтлахын тулд үндсэн чадамжуудыг дахин бүтэцлэх
- Үндэсний хөтөлбөрийн тогтолцоог бүрдүүлэх, баримт бичгийг нь боловсруулах явцад үндсэн чадамжуудыг хөгжүүлэх ирээдүйн үндэсний хөтөлбөрийн төлөвлөлтийг хийх

Дүрслэл 1. Судалгааны хүрээ



IV. Судалгааны үр дүн

- **Ирээдүйн нийгмийн мега-чиг хандлагыг шинжилж, боловсролын ирээдүйн чиглэлийг урьдчилан тодорхойлсон үр дүн нь:**
  - Мега-чиг хандлагыг тодорхойлсон: хүн амын өөрчлөлт, шинжлэх ухаан ба мэдээлэл технологийн хөгжил, эдийн засгийн нөхцөл байдал, хүрээлэн буй орчны өөрчлөлт болон нөөцийн асуудал, даяаршсан нийгмийн өөрчлөлт

- Мега-чиг хандлагын үүднээс боловсролын тулгамдсан хэрэгцээг илрүүлсэн: Нийгэм-хувь хүний боловсрол, мэдээллийн ёс зүйд тулгуурласан технологийн боловсрол, эдийн засаг-мэргэжлийн ур чадварын хөгжил (мэргэших), хүрээлэн буй орчин-ногоон боловсрол ба даяаршлын иргэншихүйн улс төрийн боловсрол
- Ирээдүйн тодорхойгүй нийгэмд мэдлэгийг хэрэглэх чадвар нь мэдлэг хуримтуулахаас илүү чухал. Иймд боловсрол нь янз бүрийн өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлж чадах, даван туулах чадвартай чадамжийг хөгжүүлэхэд төвлөрөх ёстой.

❖ **Үндсэн чадамжуудыг дахин бүтэцчилсэн үр дүн:**

- Үндсэн чадамжуудыг хувь хүний, танин мэдэхүйн/оюун ухааны болон нийгмийн чадамж гэсэн гурван том бүлэгт ангилав.
- Үндсэн чадамжийн элементүүдийг том бүлэгт ангилан сонгож, нэгтгэхдээ үндэсний түвшинд, эсвэл хөтөлбөрийн ерөнхий хүрээнд бус харин хичээл, сургуулийн түвшинд авч үзэх аргыг хэрэглэсэн болно.

Хүснэгт 1. Үндсэн чадамжуудын ангилал

Ангилсан бүлэг	Утга	Толилуулж буй том бүлгийн элементүүд
Хувь хүний чадамж	Бусад хүмүүстэй харилцахад шаардагдах чадамжууд	Ёс суртахууны мэдрэмж, өөрийгөө хянах, сэдэлжүүлэх чадвар
Танин мэдэхүйн чадамж	Суурь чадамжуудад тулгуурлан асуудал шийдвэрлэх болон тунгаан бодох, бүтээлчээр сэтгэх үйлд шаардагдах чадамжууд	Суралцах суурь чадварууд, тунгаан бодох чадвар, асуудал шийдвэрлэх ур чадвар, мэдээллийн үнэн зөв, үнэ цэнийг тогтоох чадвар болон гадаад хэлний ур чадвар
Нийгмийн чадамж	Нийгмийн харилцан үйлчлэл, нөлөөллийг үнэлэх, оролцооны явцад асуудлыг ойлгох, нийгэмд эзлэх байр сууриа олох, ажил мэргэжил дээрээ хөгжих чадамжууд	Хүмүүс хоорондын харилцааны ур чадварууд, оролцоо, хувь нэмэр болон олон улсын нийгэмлэг, соёлыг ойлгох чадвар

❖ **Ирээдүйн үндсэн чадамжийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах төлөвлөгөө**

- Ирээдүйн нийгмийн өөрчлөлттэй холбогдон, үндэсний хөтөлбөрийг боловсруулах гол чиглэлийг тогтоох чухал хэрэгцээ байв. Үйл ажиллагааны түвшинд практикт хэрэглэхэд зориулсан дэлгэрэнгүй зөвлөмж хэрэгтэй байна. Уг зөвлөмжид хичээлүүдийг зохион байгуулах, цагийг хуваарилахад стандарт болж чадах, хичээл/судлагдахууны агуулга, сургах, суралцах аргыг тусгасан байх шаардлагатай.
- Үндсэн чадамжуудыг хөгжүүлэх ирээдүйн үндэсний хөтөлбөрийн хэмжигдэхүүнүүд
  - ✓ “Боловсролын зорилго” болон “Боловсролтой хүний дүр зураг”тай холбон үндсэн чадамжуудыг нарийвчлан тодорхойлов.
  - ✓ Хичээлүүд ба хөтөлбөр дундын (хөтөлбөрүүдийн солбицол дээрх) чадамжуудыг агуулсан үндэсний хөтөлбөрийн хүрээг боловсруулав. Хичээл судлагдахууны хүрээ нь танин мэдэхүйн чадамжуудад төвлөрсөн бол хөтөлбөр дундын чадамжийн хүрээ нь хувь хүний ба нийгмийн чадамжийг онцлон авч үзсэн.
  - ✓ Үндэсний хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөө нь үндсэн чадамжуудын утга, агуулгыг тодорхойлж байхад хичээлийн хөтөлбөр нь хичээл бүрээр эзэмших үндсэн чадамжийг агуулсан. Хичээлээр эзэмших нийтлэг чадамжуудыг ерөнхий

төлөвлөгөөнд тодорхойлсон утга, агуулгад тулгуурлан боловсролын хэрэгцээ, хичээл бүрийн онцлог шинжийг авч үзэж боловсруулсан болно.

- ✓ Сургуулийн нэгж, эсвэл багш нар үндэсний хөтөлбөрт тодорхойлсон үндсэн чадамжуудын утга санаанд тулгуурлан, суралцагчдын боловсрол эзэмших хэрэгцээ, орон нутгийн онцлог шинжийг харгалзан сургуулийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

- Үндэсний боловсролын хөтөлбөрийн баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох нь
  - ✓ Боловсролын зорилго болон үндсэн чадамжууд нь органик/амьд уялдаа холбоотой байх шаардлагатай бөгөөд үндсэн чадамж бүрийн утга санаа, чадамжууд хоорондын холбоо хамаарлыг тодорхойлох хэрэгтэй. Үүнд хүснэгт, бүдүүвч зэргийг ашиглаж болно.
  - ✓ Үндэсний хөтөлбөрийг сургууль бүрийн түвшинд хэрэгжүүлж, хөгжүүлэх (боловсронгуй болгох) үйл ажиллагаанд үндсэн чадамжуудыг нилээд ерөнхий тодорхойлсон төлөвлөгөөг хичээлийн хөтөлбөрийн хамт хэрэглэнэ. Тэгэхдээ хичээлийн хөтөлбөрт сургах, суралцах аргыг үндсэн чадамжууд болон боловсролын үнэлгээний хамт ашиглахыг нарийн тодорхойлох шаардлагатай. Мөн холбогдох боловсролын агуулгыг дэлгэрэнгүй тусгах хэрэгтэй.
  - ✓ Хэрэгжилтийн түвшний үйл ажиллагааг дэмжихийн тулд шинэ хөтөлбөрийн зорилгыг хөхүүлэн дэмжсэн видео бичлэгүүд, боловсролын зорилго болон шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замыг олон нийтэд өргөн хүрээнд хүргэхэд ашиглах сонсох материалууд, шинэ хөтөлбөрийг хэрэглэхэд ашиглах сургалтын материал, гарын авлага зэргийг түгээх шаардлагатай.

Дүрслэл 2. Ирээдүйн үндсэн чадамжуудыг хөгжүүлэх үндэсний сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөө (ноорог)



V. Бодлогын мөн чанар

❖ **Үндсэн чадамжуудыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг дахин бүтэцчилсэн нь**

- Сургалтын хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөөнд үндсэн чадамжуудыг нийтлэг чадамж болохын нь хувьд хувь хүний, танин мэдэхүйн болон нийгмийн чадамж гэсэн томоохон бүлэгт ангилан тодорхойлсон.
- Хичээлийн хөтөлбөр нь чадамжуудыг хичээл бүрийн онцлог шинжтэй уялдуулан "судлагдахууны тусгай чадамж" болохын нь хувьд дахин бүтэцчилсэн.
- Хичээлийн хөтөлбөр нь минимум агуулгыг хянуур сонгох замаар агуулгын багтаамжийг багасгах учиртай.
- Сургалтын курс хичээлүүд нь мэдлэг эзэмшихээс илүүтэй мэдлэгийг чадварлаг хэрэглэхэд төвлөрөх болно.

Дүрслэл 3. Сургалтын хөтөлбөрийг дахин бүтэцлэх төлөвлөгөө



❖ **Үндсэн чадамжуудын ерөнхий тодорхойлолт, үндэсний түвшинд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйг зөвлөсөн нь**

- Үндэсний хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөө нь үндсэн чадамжуудыг танин мэдэхүй, хувь хүний, нийгмийн чадамжууд гэсэн томоохон бүлэгт хараглзуулан нийтлэг/түгээмэл чадамж болох талаас нь харуулсан. Сургуулиас зохион байгуулж буй сургалтын явцад үндсэн чадамжуудыг хөгжүүлэхийн тулд сургууль бүрийн түвшинд сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх үйл явц, холбогдох сургалтын аргын жишээ/кейс, сургалтын хөтөлбөрийн үнэлгээний талаар зөвлөх шаардлагатай.
- Хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад сургууль бүрийн түвшинд ашиглах тайлбар бүхий үндсэн чадамжуудыг анхааралтай авч үзэхийн зэрэгцээ судлагдахууны тусгай чадамжуудыг гаргаж өгөх шаардлагатай.

❖ **Сургууль, анги бүрийн түвшингээр үндсэн чадамжуудыг дахин нягталсан цар хүрээ, түвшний ялгаатай байдал**

- Үндэсний түвшинд нийтлэг чадамжуудыг сургалтын хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тодорхойлж, судлагдахууны онцлог чадамжуудыг сургууль, ангийн түвшинд хичээлийн хөтөлбөрөөр тодорхойлох ерөнхий чиглэл өгсөн. Сургууль нэгж нь үндэсний түвшинд өгсөн чиглэлд тулгуурлан хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх учиртай. Гурван бүлэг үндсэн чадамжаас танин мэдэхүйн чадамжуудыг ахлах ангийн түвшинд онцолж байна. Бага, дунд сургууль заавал эзэмших албан ёсны боловсрол эзэмшүүлэхийг зорьж байхад ахлах сургуулиудад мэргэжлийн мэдлэгийг агуулсан судлагдахууны онцлог чадамжийг эзэмшүүлэхэд онцгой анхаарах болно.

❖ **Үндэсний хөтөлбөр нь хичээлийн ба хөтөлбөр дундын чадамжийн хэсгүүдээс бүрдэх бөгөөд үндсэн чадамжийг хөгжүүлэхэд аль аль хэсэг нь чухал үүрэгтэй.**

- Сургалтын хөтөлбөр нь бүрэлдэхүүн хэсгийн хувьд хичээлүүдийн ба хөтөлбөр дундын чадамжийн хэсгүүдээс бүрдэнэ.

- ✓ Хичээл/судлагдахууны чадамжуудыг тухайн хичээлийн хүрээнд боловсруулна.
- ✓ Хичээл хоорондын уялдаа холбоог хангах, интеграцчилах чиг хандлагыг шаардаж байгаа үндсэн чадамжуудыг хөтөлбөр дундын чадамжуудын хүрээнд боловсруулах шаардлагатай.
- ✓ Хичээлүүд хоорондын хамтын ажиллагаа нь хөтөлбөр дундын чадамжийн хөгжлийг дэмжинэ.
- ✓ Багш бэлтгэх сургалтанд хөтөлбөр дундын чадамжийг хөгжүүлэх арга зүйг өргөн хэрэглэнэ.

Дүрслэл 4. Үндэсний сургалтын хөтөлбөрийн хүрээ



- ❖ **Үндэсний сургалтын хөтөлбөрийг засан сайжруулах үйл явц нь ерөнхий төлөвлөгөө ба хичээлийн хөтөлбөрийн уялдаа холбоог бэхжүүлэх боломжийг олгоно.**

  - Ерөнхий төлөвлөгөө ба хичээлийн хөтөлбөрийн уялдаа холбоог хангах үйл явц, түүний үр дүнг нягтлахын тулд ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг нь хичээл бүрийн хөтөлбөрийн хураангуйг агуулсан байх шаардлагатай. Уг баримт бичигт тулгуурлан үндсэн чадамжуудыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хэмжинэ. Уг баримт бичгийг цаашид хичээлийн хөтөлбөрийг боловсруулах үндэс суурь болгон хэрэглэнэ.

Дүрслэл 5. Ерөнхий төлөвлөгөө ба хичээлийн хөтөлбөрийн холбоо хамаарлын тогтолцоо



- **Багшийн чадамжийг хөгжүүлэхийн тулд багшийг дахин бэлтгэх сургалтын хэмжигдэхүүнийг боловсруулах**
  - Үндэсний болон орон нутгийн түвшинд багш бэлтгэх сургалтын агуулга, арга зүйг өөрчлөх шаардлагатай.
  - Багш нарт тасралтгүй/насан туршийн боловсрол эзэмшүүлэх сургалтын арга зам олон янз байх ба кредит банкны тогтолцоо төгсөлтийн дараах сургалтаас ч илүү нээлттэй болно.
  - Судалгааны бүлгүүд сургууль, орон нутгийн түвшинд дэмжлэг үзүүлснээр багш нар дээд сургуулийн оюутнууд, судалгааны бүлгүүдтэй холбогдож, шинэ зүйл сурах, харилцах өргөн боломж нээгдэнэ.

Англи хэлнээс орчуулсан С.Энхтүвшин

Эх сурвалж: Research Report, KICE 2012, p. 10-16